



Д.МЯГМАРСҮРЭН
Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуулийн багш, ахмад

ХОРИХ БАЙГУУЛЛАГААС ОРГОХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

ХОРИХ БАЙГУУЛЛАГА НЬ: Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон ялтныг олон нийтээс тусгаарлан, тэднээс үйлдэж болзошгүй гэмт үйлдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн ялтны аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй билээ. Энэ үүргийг гүйцэтгэх явцад **хоригдогч, ялтны зүгээс** албан хаагчийн үүрэг гүйцэтгэлт, улмаар албаны үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдох, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг эрмэлзэх, албан хаагчийг янз бүрийн аргаар эрхшээлдээ оруулахыг хичээх, албан хаагчийн амь бие эрүүл мэндэд халдах гэх мэт хорих анги, баривчлах, цагдан хорих байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг байнгын буюу тасралтгүй шинжтэйгээр үйлдсээр байна^{1,26}. Түүнчлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан цаашид /хоригдогсод гэх/ нь хорих анги, баривчлах, цагдан хорих байранд бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, хорих ангийн харуул хамгаалалтын сул байдал, албаны үйл ажиллагааны онцлог байдлыг ашиглан хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг эвдэх, зориулалтын саад,

төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлдсээр байна.

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай авч үзэхийн тулд хорих ангийн хэвийн үйл ажиллагааны талаар тодорхой ойлголттой байх ёстой.

Зарим судлаачид эрдэмтэд нь хорих анги, баривчлах байрны аюулгүй байдлыг тодорхойлохдоо²²⁷ “Хорих анги, баривчлах, цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, ноцтой хор уршиг учруулж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зорилгоор эрх үүрэг бүхий субъектүүдээс хэрэгжүүлж буй тасралтгүй шинж чанар бүхий арга хэмжээний цогц, оновчтой бүтэц бүрдэх явдал юм” гэж үздэг бол Хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна гэдэг нь “Хоригдогч, ялтны зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ноцтой гэмт хэрэг бүхий нуугдмал санаа, төлөвлөлтийг илрүүлэх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байхыг ойлгоно”. гэж тодорхойлжээ.

Хорих байгууллагын аюулгүй байдалд нөлөөлдөг хүчин зүйлсийг хэлбэрээс нь шалтгаалан хэд хэдэн бүлэгт хувааж үзэж болно. Үүнд:

1. Нийгэм-эдийн засгийн нөхцөл

Энэхүү бүлэг хүчин зүйл нь: улс орны нийгмийн амьдрал, ард түмний амьжиргааны түвшин, эдийн засгийн тогтвортой байдал, хөгжлийн чадавхи, улс орны гадаад харилцаа, нийгмийн үнэт зүйлсийг эрх зүйн үүднээс баталгаажуулсан байдал зэрэг олон хүчин зүйлсээр тодорхойлогддог цогц ойлголт юм.

Аливаа улсын нийгэм эдийн засгийн хөгжил, түүний түвшин зэрэг нь нийгмийн сэтгэл зүйтэй салшгүй холбоотой байдаг талаар олон жишээ

²⁶ Б.Нямгомбо. “Монгол улс цаазаар авах ялаас татгалзснаар хорих байгууллагын аюулгүй байдалд гарч болзошгүй сөрөг хандлага” илтгэл Шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл 1 дэхь хэвлэл УБ. 2012 он

²⁷ Ц.Очгэрэл. “Хорих байгууллагын аюулгүй байдлыг харуул хамгаалалтаар хангах” илтгэл Эрх зүй албаны мэдээлэл УБ. 2010 он



дурдаж болох юм. Нийгэм-эдийн засгийн байдал хэдий чинээ тогтворгүй, баталгаагүй байна төдий чинээ нийгмийн сэтгэл зүй тогтворгүй, эмзэг байхын зэрэгцээ аливаа сөрөг үр дагавар дагуулж байдаг.

Хорих ял эдлэж буй болон цагдан хоригдож буй хоригдогсад нь сэтгэл зүйн онцлог тогтворгүй байдалд байдгийн хувьд нийгэм-эдийн засгийн амьдралын аливаа өөрчлөлт, хөдөлгөөнийг маш эмзэг, сөргөөр хүлээж авдаг нь судалгааны ажиглалтаас харагдаж байна. Түүнээс гадна нийгмийн амьдралын баталгаагүй, тогтворгүй байдал нь хоригдогсдын хувьд гэр бүлийнхний амьдралын хүндрэл, үр хүүхдийн ирээдүйн баталгаагүй байдал нь үл итгэх байдал бий болгодог. Ингэснээр хорих ял эдлэж буй болон цагдан хоригдож буй этгээдүүдийн сэтгэл санаа тогтворгүй байдалд орж хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх оргох гэмт хэргийг үйлдэх нөхцөл бүрдэж байдаг юм.

2. Гэр бүлийн орчин нөхцөл

Гэр бүлийн орчин нөхцөл буюу хүний өсч торних, төлөвших хамгийн ойрын хүрээлэл нь аливаа хүний сэтгэл зүйн болон амьдрах орчин, аливаад хандах хандлага зэргийг төлөвшүүлдэг өвөрмөц бичил орчин юм.

Хорих ангийн дотоод орчинд дасан зохицох, эсхүл тодорхой хугацааг дэглэмийн өвөрмөц нөхцөлд өнгөрүүлэхэд тухайн хоригдогчийн гэр бүлийн орчинд олж авсан сэтгэл зүйн хүмүүжил, биеэ авч явах чадвар нь хууль ёсны шаардлагыг сахин мөрдөх, бусад хоригдогсодтой зөв харьцах зэрэгт голлох үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн хоригдож буй хугацаанд гэр бүлийн зүгээс үзүүлж буй материаллаг болон сэтгэл зүйн тусламж нь тухайн хоригдогчийг аливаа сэтгэл зүйн хямрал, өөрчлөлтөөс гарах, хүндрэлийг даван туулахад онцгой ач холбогдолтой байдаг. Тухайлбал: гэр бүл салалт, дотны хүнээс хагацах, гэр бүлийн амьжиргааны дор байдал, хардалт зэрэг

нь ял эдлэгсдийн сэтгэл санаанд сөргөөр нөлөөлж ямар нэгэн гэмт үйлдэлд хүргэдэг

3. Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож буй орчин нөхцөл

ШШГБ-ын харьяа анги, баривчлах, цагдан хорих байрны үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актаар зохицуулагдсан дотоод журам, дэглэм, цагийн хуваарийн дагуу зохион байгуулладаг бөгөөд зарим хоригдогсдын хувьд энэхүү өвөрмөц орчинд дасан зохицохгүй байх, улмаар сэтгэл зүйн хямралд орох явдал олонтоо тохиолддог.

Түүнчлэн хамт хоригдогсодтой харилцаанд ороход болон хорих ангийн онцлогоос шалтгаалан ажил, хөдөлмөрт хамрагдахад зарим хоригдогсод тодорхой сэтгэл зүйн хүндрэл өөрчлөлтүүд илэрдэг ба энэ бүхэн нь тухайн хоригдогчийн хувийн зан чанар, сэтгэл зүйн онцлогтой хавсран хямрал, өөрчлөлтөнд орох нөхцөл болж болзошгүй байдаг.

Энэ бүгдээс үзэхэд Оргох гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг шалтгаан нөхцлийг алба ажилтнаас болон ялтан хоригдогчийн зүгээс гэж 2 хувааж үзэж болно. Үүнд:

1-рт: Хорих анги, алба, ажилтны зүгээс

1. Хорих анги, цагдан хорих байрны орчин нөхцөлд дасан зохицож чаддаггүй, тэдэнд хууль эрх зүй, орчин нөхцлийн талаар яриа таниулга муу хийдэг
2. Албан хаагчдын эрх мэдлээ буруу ашигладаг,
3. Албан хаагчдын харьцааны доголдол
4. Албан хаагчдын дарамт, шахалт
5. Албандаа хайнга хандаж ажлын хариуцлага, сонор сэрэмж алдснаас
6. Харуул хамгаалалтын хүн хүч, техник хэрэгслийн буруу зохион байгуулалтаас

2-рт: Хоригдогч, ялтны зүгээс

1. Ялтнуудын хоорондын харилцаа



2. Ялтны дундах, гал хам, бүлэглэлийн дарамт шахалтаас
3. Ар гэрийн амьдрал түүнд тулгарч буй бэршээлээс
4. Хувь хүний өөрийн зан чанар, ял эдлэх үеийн сэтгэл санаа тогтворгүй байдлаас
5. Ажлын ачаалал, /шантрах/
6. Нуугдмал гэмт хэрэг нөхөн илрэх тохиолдолд
7. Өш хонзон санаж оргох /албан хаагчдад/
8. Ял эдлэх орчин, байгал цаг уурын өөрчлөлт, сэтгэл санааны тогтворгүй байдлаас тохиолдолын нөхцөл байдлаас болж оргох гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг.

Ихэнх санаатай гэмт хэрэг нь гэмт этгээдийн санаа зоригоор удирдан чиглүүлэгдэж буй нарийн төвөгтэй объектив үйл явц байдаг. Оргох гэмт хэрэг нь тодорхой үе шатыг дамжин явагддаг²⁸.

Үе шат гэдэг нь гэмт этгээдийн гэмт хэргийн бэлтгэлээс эхлээд бүрэн хэрэгжих хүртэлх үйлдлийг хэлнэ. Хэрэв гэм буруутай этгээд санаа бодлоо дуустал хэрэгжүүлбэл төгс гэмт хэрэг болно. Харин тэрээр өөрийн санаа бодлоо бүрэн хэрэгжүүлж чадаагүй, түүний хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар нь таслан зогсоогдсон бол төгсөөгүй гэмт хэрэг болно. Иймд аль ч үе шатанд тухайн гэмт хэрэг дуусгавар болж болно.

Ялтны зүгээс оргох гэмт хэрэг үйлдэхийн өмнө дараах үйл ажиллагааг зохион байгуулдаг гэж үзэж болно. Үүнд

- ❖ Оргож болох нөхцөл бололцоог судлах
- ❖ Оргох санааг хэрэгжүүлэх нөхцлийг бий болгох
- ❖ Оргох төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Ялтан нь оргох нөхцөл бололцоог судлах үе шат: Тухайн этгээдийн сонирхол татаж буй объектын тухай гэмт хэрэг үйлдэхэд бэлтгэх, гэмт хэрэг үйлдэх ба гэмт хэрэг нуун далдлах үйлдлийг бүтэмжтэй болгоход шаардлагатай

мэдээллийг энэ үе шатанд цуглуулж байдаг. Үүнд

- ❖ Жижүүрийн албан хаагчдын сул талыг ашиглах
- ❖ Өөрийнхөө үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дөхөм болох ялтныг элсүүлж авах
- ❖ Албан хаагчдын, ялангуяа харуул хамгаалалтын ажилтны яриаг сонсох
- ❖ Тухайн хорих ангийн объект, байшин барилгын зохион байгуулалтын онцлог, түүнд хэрхэн ойртож болох талаар ажиглалт хийх
- ❖ Хорих ангийн ойролцоох нутаг орныг судлах
- ❖ Албаны хүмүүсийн итгэлийг хуурамчаар өөртөө татаж авах зэрэг.

Ялтан нь оргох санааг хэрэгжүүлэх нөхцлийг бий болгох үе шат: Энэ үе шатанд олж авсан мэдээллийн үндсэн дээр оргох нөхцлийг бий болгох тодорхой төлөвлөгөөг боловсруулдаг. Үүнд

- ❖ Оргох төлөвлөгөөг боловсруулах /схемээр болон төсөөллөөр/
- ❖ Гэмт бүлгийг бүрдүүлэх ба бүлэг дотроо өөрсдийн хийх үйлдлээ хуваарилдаг.
- ❖ Оргоход зайлшгүй шаардлагатай хувцас, хоол хүнс, зэвсэг, хэрэгсэл, бусад зүйлийг олж авдаг.
- ❖ Янз бүрийн байдлаар хамгаалалтын бүс болон албан хаагчдыг туршиж үзэн, тэр үйл ажиллагаандаа бусдыг дасгаж байдаг.
- ❖ Объектод нэвтрэх оролдлого хийж туршиж үздэг.
- ❖ Ямар нэгэн шалтаг олж албан хаагчдаас тусламж хүсч тэдний хэрхэн яаж хандахыг шалгаж үздэг.
- ❖ Харуул хамгаалалтын болон бусад албан хаагчид үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа ажилдаа хэрхэн хандаж байгаад хяналт тавьдаг.
- ❖ Ялтны оргох төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатанд гэмт үйл ажиллагааны тухай олж авсан мэдээллийг нэгтгэн ямар харуул хамгаалалтын ээлж, ямар албан хаагчийг ашиглах гэх мэт гэмт үйлдэлийг богино хугацаанд эрс шийдэмгий байдлаар хийгдэхээр төлөвлөдөг.

²⁸ Х. Пүрэвсүрэн, ШШГА-ны уламжлал, шинэчлэлийн тойм, УБ, 2006 он 24 дахь тал



Оргох төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат: Энэ үед үйлдэл хэрэгжих явцад ямар нэгэн саад учирсан тохиолдолд тухайн ялтны сэтгэл зүйн онцлог, нөхцөл байдлаас шалтгаалж харуул хамгаалалтын болон албан хаагчидтай харгис хэргийг хандах тохиолдол байдаг байна.

Жишээ нь: 1995 онд Мааньт дахь чанга дэглэмийн хорих ангиас ялтан Ч.Дүгэрээ, Сугар нарын 9 ялтан харуулд хүч хэрэглэн, галт зэвсэг, машин техник авч оргосон. 1996 онд Авдрант дахь гяндангаас ялтан Ч.Чулуунбаатар, Н.Лхагвасүрэн, Б.Төртогтох нар 5 хүний амь насыг зэрлэгээр хөнөөж оргосон эмгэнэлт тохиолдол, мөн 2009 онд ДӨА-иас ялтан Н харуул хамгаалалтын ажилтанг хутгалан оргон зайлсан гэх мэт олон жишээг дурдаж болно.

Ялтан оргох гэмт хэрэг нь нийгмийн хор аюул ихтэй гэдэг нь хэнд ч ойлгомжтой юм. Энэ нь тухайн этгээдийг олж баривчлах хүртэл хорих ангийн харуул хамгаалалтын хэвийн үйл ажиллагаа доголдож байдаг, оргодол ялтнууд дахин давтан гэмт хэрэг үйлдэх явдал өндөр магадлалтай байдаг /оргож явах үедээ нийгэм, иргэдэд эд хөрөнгийн болон эрүүл мэндийн хохирол учруулах магадлал өндөр/ нийгмийг айдас хүйдэст автуулдаг зэрэг сөрөг хандлагыг өөртөө агуулж байдаг.

Энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг тухайн гэмт хэргийн гарах болсон шалтгаан, нөхцлийг нарийн судалж, түүний үндсэн дээр шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн ололтыг судалгаа шинжилгээний үндсэн дээр нэвтрүүлж ажиллах явдал чухал юм гэж дүгнэж байна.

Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр оргох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ гэж доорх саналыг дэвшүүлж байна.

1. ШШГЕГ-ын ТГГ-ын ажилтан, албан хаагчдын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд мөрдөх стандартыг бий болгох,

2. ШШГБ-ын үйл ажиллагааны менежментэд өөрчлөлт хийх,
3. Хорих ангийн дотоод албадын ажлын уялдаа холбоог сайжруулж сэтгэл зүйч, нийгмийн ажилтны мэргэшлийн түвшинг дээшлүүлж сэтгэл засал, сэтгэц онош хийж ялтныг ангилан сургалт хүмүүжлийн ажлыг ялгавартай зохион байгуулах,
4. Харуул хамгаалалтын албан хаагчдыг давтан сургах, онол практикийн нэгдлийг хангах зорилгоор жилд 2-оос доошгүй сарыг мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд зориулдаг байх эрх зүйн орчинг бий болгох, /сургалт/
5. Оргох гэмт хэргийг удаа дараа үйлдэж байсан этгээдүүдийн талаар судалгаа, бүртгэл хөтөлж, улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах зэрэг болно.

ОРГОСОН БОЛОН ОРГОХЫГ ЗАВДСАН ЯЛТНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

